

297



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар Н/138

Шивээговь сум


Ажилгүй байсан хугацааны цалин, хөлс
тэмдэгтийн хураамж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 113/ШШ2021/0001 дугаар "Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалыг эрхэлж байсан Д.Отгонжаргалд 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийг дуустал ажилгүй байсан хугацааны цалин 23962161 (хорин гурван сая есөн зуун жаран хоёр мянга нэг зуун жаран нэг) төгрөг, тэтгэмжийн хураамж 70200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг тус тус олгосугай.

2. Ажилгүй байсан хугацааны цалин, хөлс тэмдэгтийн хураамж 23962161 (хорин гурван сая есөн зуун жаран хоёр мянга нэг зуун жаран нэг) төгрөгийг тэтгэмжийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), нягтлан бодогч (Б.Энхмаа) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421210559